



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН
ТУШААЛ

2025 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/408

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2, 31.1.5, “ШУТИС-ийн дүрэм”-ийн 4.9.15, 4.9.16 дахь заалт, ШУТИС-ийн Ректорын зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ШУТИС-ийн бакалаврын төгсөлтийн журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. “ШУТИС-ийн бакалаврын төгсөлтийн журам”-ыг нийт багш, ажилтнуудад танилцуулах, мөрдөн хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллахыг холбогдох захиргааны нэгжийн удирдлага, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал нарт даалгасугай.
3. Энэхүү тушаалыг 2025-2026 оны хичээлийн жилийн намрын улирлаас эхлэн мөрдсүгэй.

РЕКТОР



Т.НАМНАН

367041987

	Бакалаврын төгсөлтийн журам ШУТИС-СҮ-ЖУ	Эхний хэвлэлт	2014
		Өөрчилсөн огноо	2025
		Өөрчлөлтийн дугаар	2

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэ журмаар Шинжлэх ухаан технологийн их сургууль /цаашид “ШУТИС” гэх/ -ийн бакалаврын сургалтын төгсөлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад чиглэсэн харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү журмаар зохицуулагдахгүй үйл ажиллагааг бусад холбогдох дүрэм, журмаар зохицуулна.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 Энэхүү журам нь ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрийн төгсөх оюутан, төгсөгч болон бусад оролцогч талуудыг хамарна.

ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

- 3.1 Боловсролын ерөнхий хууль
- 3.2 Дээд боловсролын тухай хууль
- 3.3 Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/143 дугаар тушаалын гуравдугаар хавсралт “Дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөлтийн журам”
- 3.4 Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/143 дугаар “Журам шинэчлэн батлах тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралт “Дээд боловсролын дипломын загвар”
- 3.5 ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам

ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 4.1 Дипломын төсөл гэж оюутан бакалаврын зэргийн боловсрол эзэмшсэнээ нотлон харуулах зорилгоор тухайн хөтөлбөрөөр эзэмшсэн суралцахуйн үр дүнгүүд буюу мэдлэг чадвар, хандлагаа ашиглан гүйцэтгэх тодорхой асуудал шийдвэрлэх даалгавар бүхий төслийн ажлыг;
- 4.2 Төслийн хичээл гэж оюутан багаар эсвэл ганцаарчилсан байдлаар асуудал шийдвэрлэх төсөл хэлбэрийн даалгавар гүйцэтгэж хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагаа практик хэрэглээ болгох хичээлийг; Хичээлийг 3-р курс судлахаар төлөвлөх ба 2-оос багагүй кредиттэй байна.
- 4.3 Төгсөлтийн шалгалт гэж оюутан тухайн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийг хэр түвшинд эзэмшсэнийг үнэлж дүгнэх зорилгоор төгсөлтийн өмнө зохион байгуулах нэгдсэн шалгалтыг;
- 4.4 Төслийн зөвлөх багш гэж оюутны судалгааны ажилд мэргэжлийн чиглэлээр болон найруулга, хэл зүй, бичлэгийн стандарт, мэдээллийн эх сурвалж ашиглах, ёс зүйн чиглэлээр тус тус зөвлөн туслах иргэнийг;
- 4.5 Төгсөх оюутан гэж тухайн бакалаврын сургалтын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний кредитийг бүрэн цуглуулж, төгсөх болзол хангасан оюутныг;



- 4.6 Төслийн удирдагч багш гэж оюутанд санал болгосон судалгааны ажлын сэдвийн хүрээнд шийдвэрлэх асуудлыг томъёолох, ажлын төлөвлөгөө гаргах, ажлын явцад зөвлөж чиглүүлэх, үр дүнг хянаж, үнэлэх чиг үүрэг бүхий иргэнийг;
- 4.7 Төслийн шүүмжлэгч гэж оюутны гүйцэтгэсэн дипломын төслийн үр дүнг хөндлөнгөөс үнэлж дүгнэхээр томилогдсон иргэнийг;
- 4.8 Төгсөлтийн төв комисс гэж төгсөлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар сургалт хариуцсан захиргааны нэгжээс томилогдсон ажлын хэсгийг;
- 4.9 Төгсөлтийн салбар комисс гэж бакалаврын дипломын төсөл хамгаалалт, төгсөлтийн шалгалтыг зохион байгуулахаар бүрэлдэхүүн сургуулиас томилогдсон ажлын хэсгийг;
- 4.10 Дээд боловсролын удирдлага мэдээллийн систем гэж Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дээд боловсролын системийг;
- 4.11 Удирдлага мэдээллийн систем гэж ШУТИС-ийн Удирдлага мэдээллийн системийг /UNIMIS/;
- 4.12 Хавсарга хөтөлбөр гэж үндсэн зэргийн хөтөлбөрийн зэрэгцээ өөр зэргийн хөтөлбөрийн чиглэлээр системтэй мэдлэг, чадвар, хандлага эзэмшүүлэх зорилго бүхий боловсролын зэрэг олгохгүй сургалтын хөтөлбөрийг;
- 4.13 Хамтарсан хөтөлбөр гэж тухайн дээд боловсролын сургалтын байгууллага хамтын ажиллагааны гэрээтэй дотоод, гадаадын эрх бүхий сургалт, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтарсан эсвэл давхар зэрэг олгох зорилгоор хэрэгжүүлэх ижил түвшний нэгдсэн сургалтын хөтөлбөрийг;
- 4.14 Хос хөтөлбөр гэж тодорхой болзол хангасан оюутан өөрийн элссэн үндсэн хөтөлбөрөөр суралцахын зэрэгцээ сонирхсон чиглэлээр хос мэргэжил эзэмшиж давхар зэрэгтэй төгсөх сургалтын хөтөлбөрийг.

ТАВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЧИГ ҮҮРЭГ

5.1. ШУТИС-ийн Ректор

- 5.1.1. ШУТИС-ийн диплом, хавсралтын загварыг батална.
- 5.1.2. Төгсөлтийн төв комиссын бүрэлдэхүүнийг батална.
- 5.1.3. Төгсөлтийн салбар комисс, дипломын төслийн сэдэв, удирдагч, зөвлөх, төгсөлтийн шалгалт өгөх оюутны нэрсийг тушаалаар батална.
- 5.1.4. Төгсөлтийн үйл ажиллагааны явцтай танилцаж санал, зөвлөмж өгнө.
- 5.1.5. Төгсөгчид дэд бакалавр, бакалаврын зэрэг, диплом олгох тушаал гаргана.
- 5.1.6. Төгсөлтийн үйл ажиллагааны үр дүнгийн тайлантай танилцаж үнэлэлт, дүгнэлт өгнө.

5.2. Төгсөлтийн төв комисс

- 5.2.1. Сургалтын нэгдсэн хуанлид заасан хугацаанд төгсөлтийн үйл ажиллагааг төлөвлөн удирдлагаар хангаж, явцад хяналт тавин ажиллана.
- 5.2.2. Төгсөлттэй холбоотой санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ.
- 5.2.3. Төгсөлтийн ёслолын ажиллагааны удирдамжийг батална.

5.3. Төгсөлтийн салбар комисс

- 5.3.1. Дипломын төслийн хамгаалалт, төгсөлтийн шалгалтын үйл явцыг удирдан зохион байгуулна.
- 5.3.2. Төгсөгч оюутны дипломын төсөл, төгсөлтийн шалгалтын үр дүнг үнэлж, тогтоол, шийдвэр гаргаж, баталгаажуулна.

5.4. Сургалт эрхэлсэн захиргааны нэгж

- 5.4.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шаардлагад нийцүүлэн ШУТИС-ийн диплом, хавсралтын загварыг бэлтгэнэ.



- 5.4.2. Төгсөлтийн шалгалт, дипломын төсөл хамгаалалтын хугацааг тухайн хичээлийн жилийн сургалтын нэгдсэн хуанлид тусгаж төлөвлөнө.
- 5.4.3. Төгсөлтийн төв комиссын бүрэлдэхүүн, ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулна.
- 5.4.4. Дипломын төсөл бичих болон төгсөлтийн шалгалт өгөх оюутны нэрс, дипломын төслийн сэдэв, удирдагч, зөвлөх батлах тухай, төгсөлтийн салбар комисс батлах тухай Ректорын тушаалын төсөл бэлтгэнэ.
- 5.4.5. Төгсөлтийн салбар комиссын үйл ажиллагааг удирдлагаар хангаж, бүрэлдэхүүн сургуулийн сургалт хариуцсан нэгжтэй хамтран ажиллана.
- 5.4.6. Оюутан төгсөх оюутны шаардлага хангасан эсэхийг хянаж баталгаажуулна.
- 5.4.7. Төгсөлтийн салбар комиссын тогтоол, шийдвэрийг үндэслэн төгсөгчид дэд бакалавр, бакалаврын зэрэг, диплом олгох тушаалын төсөл боловсруулна.
- 5.4.8. Төгсөлтийн ёслолын ажиллагааг оюутны үйлчилгээ хариуцсан захиргааны нэгжтэй хамтран зохион байгуулна.
- 5.4.9. Төгсөгчийн дипломын хуулбар, хавсралтын баталгаажсан хувь, холбогдох баримтыг ШУТИС-ийн архивд хүлээлгэн өгнө.
- 5.4.10. Төгсөлтийн үйл ажиллагааны үр дүнгийн тайланг бэлтгэж Ректорын зөвлөлд танилцуулна.
- 5.5. **Мэдээллийн технологийн төв**
- 5.5.1. Удирдлага мэдээллийн систем дэх төгсөлтийн үйл ажиллагааны дэд системийг шаардлагад нийцүүлэн, тасралтгүй хөгжүүлнэ.
- 5.5.2. Удирдлага мэдээллийн системийн найдвартай, хэвийн ажиллагааг хангана.
- 5.6. **Бүрэлдэхүүн сургуулийн дипломын нарийн бичгийн дарга**
- 5.6.1. Дипломын төслийн сэдэв сонголтыг бүрэлдэхүүн сургуулийн түвшинд зохион байгуулна.
- 5.6.2. Оюутны суралцсан хугацааны дүн тулгалтыг хийж, хянан баталгаажуулна.
- 5.6.3. Төгсөх оюутны төгсөлтийн шалгалт өгөх, дипломын төсөл бичих эсэх шийдвэрийг бүрэлдэхүүн сургуулийн сургалт хариуцсан нэгжид мэдээлнэ.
- 5.6.4. Төгсөлтийн шаардлага хангасан оюутны дипломын төслийн нэр, удирдагч, зөвлөх, шүүмжлэгчийн бүртгэлийг удирдлага мэдээллийн системд оруулна.
- 5.6.5. Дипломын төслийн урьдчилсан, жинхэнэ хамгаалалт, төгсөлтийн шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулна.
- 5.6.6. Дипломын үнэт цаас, хавтас, блокчэйд хадгалах төлбөр, ёслолын арга хэмжээнд шаардлагатай зардлын мэдээллийг оюутанд хүргэж, холбогдох газарт төвлөрүүлнэ.
- 5.6.7. Диплом гардуулах үйл ажиллагааг оюутны үйлчилгээ хариуцсан захиргааны нэгжтэй хамтран зохион байгуулна.
- 5.7. **Бүрэлдэхүүн сургуулийн сургалт хариуцсан нэгж**
- 5.7.1. Хуанлид заасан хичээл сонголтын хугацаанд бакалаврын хөтөлбөрийн оюутнуудын дипломын төсөл сонголтыг зохион байгуулна.
- 5.7.2. Дээд боловсролын удирдлага мэдээллийн систем дэх бакалавр оюутны бүртгэл, бүртгэлийн хугацааг хянаж баталгаажуулна.
- 5.7.3. Дэд бакалавраар төгсөх оюутны хүсэлтийг хүлээн авч, дүнгийн мэдээллийг харьяалагдах тэнхимд өгнө.



- 5.7.4. Шилжин ирсэн, бусад хэлбэрээр элсэгч оюутны суралцсан хугацааны дүн, дүйцүүлэн тооцуулсан хичээлийн мэдээллийг харьяалагдах тэнхимд өгнө.
- 5.7.5. Дипломын төсөл сонгосон, төгсөлтийн шаардлага хангасан оюутныг төгсөх оюутнаар бүртгэн, оюутны мэдээллийг хянан баталгаажуулна.
- 5.7.6. Тэнхимээс ирүүлсэн төгсөлтийн салбар комиссын бүрэлдэхүүнийг хянаж, сургалт эрхэлсэн захиргааны нэгжид хүргэнэ.
- 5.7.7. Урьдчилсан болон жинхэнэ хамгаалалтын үед оюутны суралцсан хугацааны дүнгийн хуудсыг баталгаажуулан төгсөлтийн салбар комисст хүргүүлнэ.
- 5.7.8. Төгсөлтийн салбар комиссоос дараах материалыг хүлээн авч, сургалт хариуцсан захиргааны нэгжид хүлээлгэн өгнө. Үүнд:
- Төгсөлтийн салбар комиссын хурлын шийдвэр
 - Төгсөлтийн салбар комиссын хурлын тогтоол, тэмдэглэл
 - Төгсөгч оюутны дүнгийн хуудас
 - Төгсөгч оюутны дэлгэрэнгүй мэдээлэл /маягт/
- 5.8. **Төслийн удирдагч багш**
- 5.8.1. Дипломын төсөл сонгосон оюутны судалгааны ажлын сэдвийн шийдвэрлэх асуудлыг томьёолох, ажлын төлөвлөгөө гаргах, ажлын явцад зөвлөж чиглүүлэх, үр дүнг хянаж, явцыг үнэлэх үйл ажиллагааг гүйцэтгэнэ.
- 5.8.2. Дипломын төсөл сонгосон бүх түвшний суралцагчдыг хамруулан улирлын турш хуваарийн дагуу семинар, хэлэлцүүлэг зохион байгуулна.
- 5.9. **Төслийн зөвлөх багш**
- 5.9.1. Оюутны судалгааны ажилд мэргэжлийн чиглэлээр болон найруулга, хэл зүй, бичлэгийн стандарт, мэдээллийн эх сурвалж ашиглах ёс зүйн чиглэлээр зөвлөнө.
- 5.10. **Төгсөх оюутан**
- 5.10.1. Хуанлийн хугацаанд дипломын төсөл сонгон судалгааны ажлыг чанартай гүйцэтгэнэ. Дипломын төсөл бичихгүй оюутан төгсөлтийн шалгалт сонгоно.
- 5.10.2. Бакалаврын хөтөлбөрийн оюутан 90 кредит судалсан боловч цаашид суралцах боломжгүй болсон тохиолдолд дэд бакалаврын зэргээр төгсөх хүсэлт гаргаж, бичил төсөл гүйцэтгэх эсвэл төгсөлтийн шалгалт өгнө.

ЗУРГАА. ДИПЛОМЫН ТӨСЛИЙН СЭДЭВ СОНГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 6.1. Бакалаврын дипломын төслийн өмнө сургалтын төлөвлөгөөний мэргэших хичээлд байгаа төслийн хичээл сонгон судлахдаа дипломын төслийн сэдэв сонгож урьдчилсан судалгаа, туршилт хийнэ.
- 6.2. Дипломын төслийн сэдвийг тэнхим тодорхойлж, бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд оюутнуудад нээлттэй мэдээлж, сэдэв сонгох ажлыг зохион байгуулна.
- 6.3. Тэнхим зөвшөөрсөн тохиолдолд нэг сэдвийн дор 3 хүртэл оюутан дипломын төслийг хамтран гүйцэтгэж болно. Дипломын төсөл бүрд нэг удирдагч, хоёр хүртэлх зөвлөх багшийг томилон ажиллуулна.
- 6.4. Төслийн хичээлийг амжилттай дүгнүүлсэн, төгсөх оюутны шаардлага хангасан оюутан дипломын төслийг сонгоно.
- 6.5. Дипломын төслийг чанаржуулах зорилгоор оюутан дипломын төслийн сонгосон сэдвийн дагуу үйлдвэр, байгууллагад дадлага хийж болно.



- 6.6. Дэд бакалаврын зэргээр төгсөх оюутан хөтөлбөрийн онцлогоос хамаарч бичил төсөл сонгож гүйцэтгэнэ.
- 6.7. Бакалаврын дипломын төсөл, бичил төслийн сэдэв, удирдагч, зөвлөх багшийг ректорын тушаалаар баталгаажуулна.
- 6.8. Хөтөлбөрийн онцлог, дипломын төсөл удирдах багшийн хүрэлцээ, оюутны хүсэлтийг харгалзан дипломын төсөл гүйцэтгэх, эсвэл төгсөлтийн шалгалт өгөх эсэхийг хөтөлбөр хариуцсан тэнхим шийдвэрлэнэ.
- 6.9. Хүндэтгэн үзэх шалтгаанаар дипломын төсөл, бичил төсөл, төгсөлтийн шалгалтыг хичээл сонголт 2-оор баталгаажуулаагүй оюутны хүсэлтийг бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт хариуцсан нэгжийн саналыг үндэслэн сургалт хариуцсан захиргааны нэгж шийдвэрлэнэ.

ДОЛОО. ТӨГСӨХ ОЮУТНЫ БҮРТГЭЛ

- 7.1. ШУТИС-ийг дэд бакалавр, бакалаврын зэргээр төгсөх оюутан дараах шаардлагуудыг хангасан тохиолдолд төгсөх оюутнаар бүртгэнэ. Үүнд:
Бакалаврын зэргээр:
 - 7.1.1. Үнэлгээний голч дүн 2.00 ба түүнээс дээш байх;
 - 7.1.2. Дээд боловсролын удирдлага мэдээллийн системд 3.0 жилээс доошгүй хугацаанд бүртгэлтэй байх;
 - 7.1.3. Төгсөх улиралд төгсөлтийн шалгалт эсвэл дипломын төслөөс гадна 15 хүртэлх кредитийн хичээл сонгосон байх;
 - 7.1.4. Гадаадын их сургуультай хамтарсан хөтөлбөрөөр төгсөгч оюутан хамтрагч сургуулийг төгсөж бакалаврын диплом авсан байх.Дэд бакалаврын зэргээр:
 - 7.1.5. Дээд боловсролын удирдлага мэдээллийн системд 2.5 жилээс доошгүй хугацаанд бүртгэлтэй байх;
 - 7.1.6. Тухайн улиралд төгсөлтийн шалгалт эсвэл бичил төсөл сонгосон байх.
- 7.2. Оюутан тодорхой кредитийг дүйцүүлэн тооцуулсан тохиолдолд дээд боловсролын удирдлага мэдээллийн системд бүртгэлтэй байх шаардлагын хугацаа богиносно. Энэ тохиолдолд кредитийг дүйцүүлэн тооцуулсан талаарх мэдээллийг сургууль албан бичгээр Боловсролын ерөнхий газарт гаргана.
- 7.3. Хос хөтөлбөрөөр суралцаж буй оюутан анх элссэн хөтөлбөрөөр төгссөний дараа, дараагийн хөтөлбөрт төгсөх оюутнаар бүртгүүлнэ.

НАЙМ. ТӨГСӨЛТИЙН САЛБАР КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН, ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 8.1. Бакалаврын төгсөлтийн салбар комисс нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэй байна.
 - 8.1.1. Комиссын дарга нь ШУТИС-д үндсэн орон тоон дээр ажилладаггүй, гаднын байгууллагын төлөөлөл байна.
 - 8.1.2. Комиссын нийт бүрэлдэхүүний 30-аас багагүй хувь нь гаднын байгууллагын төлөөлөл байна.
 - 8.1.3. Салбар дундын хөтөлбөр(88xxxx индекс)-ийн төгсөлтийн салбар комиссыг холбогдох тэнхимүүдийн саналыг үндэслэн өргөтгөн зохион байгуулж болно.



- 8.2. Бакалаврын дипломын төслийн хамгаалалт нь урьдчилсан болон жинхэнэ хамгаалалт гэсэн 2 үе шаттай явагдах ба урьдчилсан хамгаалалтад салбар комиссын сургууль талын төлөөлөл ажиллана.
- 8.3. Урьдчилсан хамгаалалт болон жинхэнэ хамгаалалтын хоорондын хугацаа ажлын 5 хоногоос багагүй байна.
- 8.4. Дипломын төслийн хамгаалалт, төгсөлтийн шалгалт авах үйл ажиллагааг төгсөлтийн салбар комиссын тогтоосон дэгийн дагуу зохион байгуулна.
- 8.5. Оюутан урьдчилсан болон жинхэнэ хамгаалалтад дипломын төслийн илтгэл, танилцуулга хийнэ. Комиссын гишүүд дипломын төслийн агуулгын хүрээнд асуулт тавьж хариулт авна.
- 8.6. Жинхэнэ хамгаалалтын үед салбар комиссын нарийн бичгийн дарга төслийн явцын үнэлгээ болон хөндлөнгийн шүүмжийн үнэлгээг төгсөлтийн салбар комисст танилцуулна.
- 8.7. Төгсөлтийн шалгалтын материалыг (тест, асуулт гэх мэт) хөтөлбөр хариуцсан тэнхим боловсруулан, бүрэлдэхүүн сургуулийн захирлаар батлуулах ба шалгалтын үйл ажиллагаа нь 3 хүртэл цаг үргэлжилнэ.
- 8.8. Төгсөлтийн салбар комисс дипломын төсөл хамгаалалт, төгсөлтийн шалгалтын үнэлгээг нэгтгэн шийдвэр, тогтоолыг батлан, төгсөгч оюутанд танилцуулна.
- 8.9. Дипломын төсөл хамгаалалт, төгсөлтийн шалгалтад "С" үнэлгээнээс доош дүгнэгдсэн оюутныг тодорхой хугацаагаар хойшлуулах ба хугацааг төгсөлтийн салбар комисс шийдвэрлэнэ.
- 8.10. Төгсөлтийн салбар комисс дипломын төсөл хамгаалалт, төгсөлтийн шалгалтын явцад тэмдэглэл хөтөлнө.
- 8.11. Тогтоол, шийдвэрийг 3 хувь үйлдэж бүрэлдэхүүн сургуулийн сургалт хариуцсан нэгжид хүргүүлнэ.

ЕС. ДИПЛОМЫН ТӨСӨЛ, ТӨГСӨЛТИЙН ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭ

- 9.1. Төгсөх оюутны дипломын төслийн явцыг харьяалах тэнхим үе шаттайгаар үнэлж, сайжруулах санал, зөвлөмж өгөх ба дипломын төслийн гүйцэтгэлийг хангалттай гэж үзсэн тохиолдолд урьдчилсан хамгаалалтад орох зөвшөөрөл олгоно.
- 9.2. Дипломын төслийн явцын үнэлгээ 50 хүртэл оноотой байх дипломын төслийн явцын үр дүнг харгалзан удирдагч багш болон тэнхимийн бүрэлдэхүүн хамтран шийдвэрлэнэ.
- 9.3. Урьдчилсан хамгаалалтыг салбар комиссын сургуулийн төлөөлөл зохион байгуулах ба дипломын төслийн гүйцэтгэл, хамгаалалтын үр дүнгээс хамааран 20 хүртэл оноогоор дүгнэнэ.
- 9.4. Сургалтын төлөвлөгөөнд заасан хичээлийг бүрэн судалж, зохих кредитийг цуглуулсан, урьдчилсан хамгаалалтад амжилттай дүгнэгдсэн оюутан жинхэнэ хамгаалалтад орно.
- 9.5. Төгсөлтийн салбар комисс нь оюутны илтгэх чадвар, асуултад хариулсан байдал, шүүмжийн болон явцын үнэлгээ зэргийг харгалзан дипломын төслийн жинхэнэ хамгаалалтыг 30 хүртэл оноогоор дүгнэнэ.
- 9.6. Төгсөлтийн шалгалт нь тухайн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлүүдийн агуулгын хүрээнд бэлтгэсэн тест болон асуулга хосолсон хэлбэртэй



байх ба 100 хүртэл оноогоор дүгнэнэ. Тестийн хэсэг 60 хүртэл, асуулга хэсэг 40 хүртэл оноотой байна.

- 9.7. Төгсөх оюутан дипломын төслийн хамгаалалт болон төгсөлтийн шалгалтаас “С” ба түүнээс дээш үнэлгээ авна.
- 9.8. Дипломын төслийн урьдчилсан хамгаалалтын үр дүнгээр төслийн гүйцэтгэл хангалтгүй байх тохиолдолд дараах нөхцөлүүдэд “SP” эсвэл “NP” тэмдэглэгээ тавина.
 - 9.8.1. “SP”-Satisfactory progress: Оюутны дипломын төслийн гүйцэтгэл дутуу хэдий ч (75 хувиас дээш тохиолдолд) цаашид бие даан ажиллаж тодорхой үр дүнд хүрэх боломжтой гэж үзвэл, төгсөгч оюутны дүнгийн хуудсанд “SP” тэмдэглэгээг тавина. Энэ тохиолдолд оюутны дипломын төслийн сэдэв болон удирдагч багшийг өөрчлөхгүй ба оюутан 2 улирлын дотор нэмж кредитийн төлбөр төлөхгүйгээр дипломын төсөл, ажлаа хийж гүйцэтгэн хамгаалалтад орох эрхтэй.
 - 9.8.2. “NP”-No Progress: Оюутны дипломын төслийн гүйцэтгэл 75 хувьд хүрээгүй, удирдагч багш оюутныг цаашид төслөө дуусгах боломжгүй гэж үзвэл төгсөгч оюутны дүнгийн хуудсанд “NP” тэмдэглэгээг тавина. Энэ тохиолдолд оюутны дипломын төслийн сэдэв болон удирдагч багш өөрчлөгдөх ба оюутан дахин төгсөгч оюутнаар бүртгүүлж кредитийн төлбөр төлнө.

АРАВ. ДЭЭД БОЛОВСРОЛЫН ДИПЛОМ ОЛГОХ

- 10.1. Төгсөлтийн салбар комиссын шийдвэр, тогтоолыг үндэслэн төгсөгч оюутанд диплом, энгэрийн тэмдэг, дипломын нэмэлт хавсралт олгоно.
- 10.2. Төгсөгч оюутан 3.60 ба түүнээс дээш үнэлгээний голч дүнтэй суралцсан бол “Онцлох” тусгай тэмдэг бүхий диплом олгоно.
- 10.3. Дотоодод болон олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр төгсөгчид магадлан итгэмжлэлийн тэмдэгтэй диплом олгоно.
- 10.4. Хавсарга хөтөлбөрөөр төгсөж буй төгсөгчид тухайн хөтөлбөрийн боловсролын зэрэг олгохгүй, хавсарга хөтөлбөрөөр суралцсаныг батлах нэмэлт гэрчилгээ олгоно.
- 10.5. Дотоод, гадаадын их сургуультай хамтарсан хөтөлбөрөөр төгсөж буй төгсөгчид тухайн бүрэлдэхүүн сургуулийн хамтарсан хөтөлбөрийн диплом олгоно.
- 10.6. Төгсөлтийн ёслолын үйл ажиллагааг төгсөлтийн төв комиссын баталсан удирдамжийн дагуу жилд 2 удаа зохион байгуулна.
 - Төгсөлтийн ёслолын арга хэмжээнд төгсөгчид, гэр бүл, найз нөхдийг оролцуулан эрдмийн баяр болгон тэмдэглэнэ.
 - Төгсөгчдөд ШУТИС-ийн Ректорын тушаалыг уншиж танилцуулан, ШУТИС-ийн диплом, энгэрийн тэмдгийг хүндэтгэлтэйгээр ёслол төгөлдөр гардуулна.

АРВАН НЭГ. ДИПЛОМЫН НЭМЭЛТ ХАВСРАЛТ

- 11.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөлтийн журамд нийцүүлэн нэмэлт хавсралт олгоно.



- 11.2. Нэмэлт хавсралт нь төгсөгчийн хувийн мэдээлэл болон сурлагын амжилт, эрдэм шинжилгээний бүтээл, шагнал, урамшуулал, олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдлыг илэрхийлэх мэдээлэл агуулсан байна.
- 11.3. Нэмэлт хавсралтыг хэвлэмэл эсвэл цахим хэлбэрээр блокчэйн технологи ашиглан олгоно.

АРВАН ХОЁР. ДИПЛОМ НӨХӨН ОЛГОХ

- 12.1. Дээд боловсролын диплом, дипломын хавсралтыг нөхөн авах хүсэлтийг сургалтын хуанлид заасан хугацаанд, холбогдох нэгж хүлээн авах ба хүсэлт гаргасан шалтгаанаас хамаарч хүснэгтэд заасан материалыг бүрдүүлнэ.

д/д	Бүрдүүлэх материал	Шалтгаан			
		Кредит систем рүү хөрвүүлэн авах	Хаяж, гэсэн	Овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээ өөрчилсөн	Гаднын нөлөөгөөр гэмтсэн
1	Иргэний үнэмлэхийн лавлагаа	✓	✓	✓	✓
2	Өмнө олгосон диплом, дипломын хавсралтын эх хувь	✓			
3	Төгсөгчийн мэргэжил, мэргэжлийн зэрэг, диплом олгох тухай Ректорын тушаалын архивын лавлагаа	✓	✓	✓	✓
4	ШУТИС-ийн архивын диплом, хавсралтын лавлагаа	✓	✓	✓	✓
5	Суралцсан хугацааны сургалтын төлбөрийн хэлбэрийг нотлох бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын тодорхойлолт (Хэрэв боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр сургалтын зардлаа төлүүлж байсан бол Боловсролын зээлийн сангийн тодорхойлолт)		✓	✓	✓
6	Гаднын нөлөөллөөр (гал, усны гамшгийн үеэр) үрэгдсэн бол холбогдох байгууллагын тодорхойлолт				✓
7	Нэр сольсон гэрчилгээ			✓	
8	Хувь хүний өргөдөл, хүсэлт	✓	✓	✓	✓
9	Хураамж төлсөн баримт	✓	✓	✓	✓

- 12.2. ШУТИС-ийн Сургалт эрхэлсэн захиргааны нэгж нөхөн олгох диплом, дипломын хавсралтыг тухайн бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт эрхэлсэн нэгж, холбогдох тэнхимтэй хамтран, батлагдсан загварын дагуу олгоно.
- 12.3. Дээд боловсролын дипломыг шинэчлэх, нөхөн олгох үйл ажиллагааг хичээлийн жилд хоёр удаа намар, хаврын улирлын төгсөлтийн үйл ажиллагааны дараа олгоно.
- 12.4. Дүнгийн хавсралтгүй олгогдож байсан дипломыг нөхөн олгохгүй.
- 12.5. Шинэчлэн олгох дипломын хичээлийн нэр болон үнэлгээг одоо мөрдөж буй сургалтын төлөвлөгөөний хичээлийн нэр, “Оюутны мэдлэгийг үнэлэх журам”-ын үнэлгээнд тус тус үндэслэн, тухайн тэнхимийн саналаар дүйцүүлэн шийдвэрлэнэ.
- 12.6. Өмнө олгосон дипломын дугаар дахин олгох дипломд хэвээр хадгалагдана.

ШУТИС-ийн ректорын 2025 оны 12 дугаар сарын
24-ний өдрийн А/408 дугаар тушаалын хавсралт



- 12.7. Өмнө олгосон дипломын дугаар тодорхойгүй тохиолдолд холбогдох баримт, нотолгоонд үндэслэн шинээр дугаар олгоно.
- 12.8. Дээд боловсролын диплом нөхөн олгох тухай асуудлыг сургалт эрхэлсэн захиргааны нэгж хянан эцэслэх ба ШУТИС-ийн Ректорын тушаалаар баталгаажуулна.
- 12.9. Шинэчлэх диплом, дипломын хавсралтын эх хувийг (хуучин) хураан авна.
- 12.10. Нөхөн олгож буй диплом дээр нөхөн олгосон тухай тэмдэг дарна.
- 12.11. Сургалт эрхэлсэн захиргааны нэгж нөхөн олгосон дипломын баримтыг ШУТИС-ийн архивд хүлээлгэн өгнө.

-----oOo-----